



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2018 оны 08 сарын 30 өдөр

Дугаар A/512

Булган

Хүндэтгэл үзүүлэх тухай

Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Монгол улсын Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Сайхан сумын уугуул, МУГЖ Ж.Одмаагийн “Санаж явах ижий” дууны 25 жилийн ойн уран бүтээлийн тоглолтод хүндэтгэл үзүүлсүгэй.
2. Хүндэтгэл үзүүлэхэд шардагдах 267 500 /хоёр зуун жаран долоон мянга таван зуу/ төгрөгийг хавсралтаар баталсугай.
3. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ

